

## **СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, үйлчлэх, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг цогц байдлаар “зохистой хэрэглээг” бий болгох үндсэн зорилгыг удирдлага болгон дараахь байдлаар тусгалаа.

1. Хуулийн төслийн 3 дугаар зүйлд “согтууруулах ундаа” гэж хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, тэдгээрийн үндсэн дээр бэлтгэсэн ундаа, шар айраг, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архийг, “согтууруулах ундааны эргэлт” гэж согтууруулах ундааг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхийг тус тус ойлгохоор тусгасан.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгох зорилгоор энэхүү хууль нь согтууруулах ундааг ашиг олох зорилгогүйгээр, хувийн хэрэгцээнд зориулан уламжлал аргаар, байгалийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн ашиглаж үйлдвэрлэх, хэвийн хэрэглээнд зориулан улсын хилээр нэвтрүүлэх болон гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын олон улсын байгууллага, тэдгээртэй адилтгах бусад байгууллагын албан хэрэгцээнд зориулан согтууруулах ундааг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх харилцаанд үйлчлэхгүй байхаар тусгасан.

2. Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт согтууруулах ундааны үйлдвэрлэлтэй холбоотой зохицуулалтыг тусгасан. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг тодорхой тусгаж, тусгай зөвшөөрөл олгох төсөл сонгон шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батлах болон тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглох, тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага зэргийг тодорхойлсон.

Мөн энэхүү бүлэгт согтууруулах ундаа үйлдвэрлэхэд тавигдах шаардлагуудыг шинээр тодорхойлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тоо, хэмжээ, хатуулгыг бүртгэж, эрх бүхий байгууллагад тогтмол мэдээлэх, орц, найрлага, түүхий эд, этилийн спиртийн агууламж ижил, нэг төрлийн согтууруулах ундааг нэгээс дээш нэрээр үйлдвэрлэх, тусгай зөвшөөрөл олгосон этгээдээс тогтоосон тодорхой доод хэмжээг заавал үйлдвэрлэж байх зэрэг шаардлагыг тогтоосон.

Үйлдвэрлэсэн согтууруулах ундааны шошго, савлагаанд тавигдах шаардлагыг мөн тодорхойлж, гадаад улсад экспортлохоос бусад тохиолдолд худалдаанд гаргах согтууруулах ундааны савалгааны хэмжээнд тавигдах шаардлагыг тогтоосон бөгөөд энэ нь согтууруулах ундааны зохистой хэрэглээг бий болгох зорилготой.

3. Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт согтууруулах ундаа импортлох, экспортлох үйл ажиллагааны талаархи зохицуулалтыг тусгаж, согтууруулах ундаа импортлох зөвшөөрлийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох, нэг жилд импортлох согтууруулах ундааны нэр, төрөл бүрийн хэмжээ нь өмнөх жилд Монгол Улсад үйлдвэрлэсэн тухайн нэр, төрлийн согтууруулах ундааны тодорхой хувиас илүүгүй байх тухай зохицуулалтыг тусгасан.

4. Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг тусгалаа. Ингэхдээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг улсын хэмжээнд нэгдмэл байдлаар Засгийн газар баталдаг байх, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цэгийн тоо, нормативыг тогтоох асуудлыг хуульчлах, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны төрөл, зэрэглэлийг тогтоож, тэдгээрийн онцлогт тохируулан үйл ажиллагаа явуулах, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийг ялгамжтайгаар тогтоох зэрэг зохицуулалтыг боловсруулсан.

Тухайлбал, согтууруулах ундаа худалдах болон согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь тус бүр 2 төрөлтэй байх бөгөөд тэдгээрийн эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь болон тэдгээрт тавигдах шаардлага нь харилцан адилгүй байх, үйл ажиллагааны чиглэл, онцлогт нийцсэн байхаар зохицуулалтыг боловсруулсан.

Мөн энэхүү бүлэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг дуусгавар болгох, хүчингүй болгох тухай зохицуулалтыг боловсронгуй болгож, үндэслэл бүрийг хуулийн төсөлд тодорхой тусгасан. Түүнчлэн нийтийг хамарсан аливаа арга хэмжээний үеэр согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалахыг хориглох, олон нийтийг хамарсан түр хугацааны, эсхүл нэг удаагийн шинжтэй арга хэмжээний үед согтууруулах ундаагаар үйлчлэх түр зөвшөөрөл олгож болох, түүнийг олгох журмыг тусгасан.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаархи зохицуулалтыг шинээр боловсруулж, уламжлалт буюу хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зааснаас гадна согтууруулах ундааг зайнаас /холбоо, мэдээллийн сүлжээ ашиглан/ болон өөртөө үйлчлэх автомат төхөөрөмж ашиглан, эсхүл гар дээрээс худалдах, түүгээр үйлчлэх, согтууруулах ундааг гэрийн хаягаар хүргэх зэргийг мөн хориглосон зохицуулалтыг тусгаж, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох өдөрт долоо хоног бүрийн ням гараг, эрүүл мэндийг хамгаалах өдөр, гэр бүлийн өдөр, залуучуудын өдөр, хичээлийн жилийн нээлт, хаалт гэх зэрэг өдрүүдийг нэмж тусгасан.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарын тухайд тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран харилцан адилгүй байхаар тусгасан ба аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цаг, өдрийн хязгаарыг хуульд заасан дээр нэмж тогтоож болохоор заасан.

Мөн согтууруулах ундааны хэрэглээ, түүний худалдаатай холбоотой үйл ажиллагааны талаархи дараахь шинэлэг зохицуулалтыг хуулийн төслийн энэхүү бүлэгт тусгасан:

- согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйлчлүүлэгчид зориулсан худалдан авсан согтууруулах ундааг хэрэглэх танхимтай байх;
- согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс худалдан авсан согтууруулах ундааг зөвхөн дээр дурдсан танхимд хэрэглэх;
- согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч 35 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг үйлдвэрийн лонх, савалгаатай нь худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох;
- согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний танхимдаа халуун, хүйтэн зуушаар үйлчилдэг байх; үйлчлүүлэгчид ундны усаар үнэ төлбөргүй үйлчлэх;
- согтууруулах ундаагаар үйлчлэх танхимд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох болон хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүсэх хор уршгийн талаар санамж, такси, нийтийн тээврийн үйлчилгээний талаархи мэдээллийг байршуулах;
- согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн согтууруулах ундааг борлуулах, түүгээр бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан байх;
- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан нь үйлчлүүлэгч хуульд заасан насанд хүрээгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийн өмнө хуулиар зөвшөөрөгдсөн насанд хүрсэн эсэхийг шалгах зорилгоор үйлчлүүлэгчийн бичиг баримтыг заавал шалгах;
- хорин нэгэн насанд хүрээгүй, эсхүл согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсний улмаас бусдад учруулсан гэм хорыг согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцах.

5. Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой зохицуулалтыг тусгаж, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон хүн, газрыг тодорхойлж, гудамж талбай, парк, цэцэрлэгт хүрээлэн зэрэг хуулиар хориглосон олон нийтийн бусад газруудад согтууруулах ундааны зүйл хэрэглэх, нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч явахыг хориглох, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлсэн.

6. Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурах, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэг зорилго бүхий аливаа үйл ажиллагааг хориглох тухай болон Архидан согтуурахтай тэмцэх сангийн талаархи зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал, энэхүү бүлэгт:

- аливаа спортын арга хэмжээг согтууруулах ундааны нэрээр нэрлэх, спортын болон соёл, урлагийн арга хэмжээ, нэвтрүүлгийн үеэр согтууруулах ундааны зар сурталчилгаа явуулах, байршуулах;

- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд хямдрал, урамшуулал зарлах, хөнгөлөлттэй үнэ, нөхцөлөөр худалдах, үйлчлэх;
- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч согтууруулах ундаагаар бусдад үнэ төлбөргүй үйлчлэх;
- согтууруулах ундаагаар дээж, загвар хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчлэх, бусдыг дайлах, амталгаа зохион байгуулах;
- хэмжээ, этилийн спиртын агууламжийн хувьд харилцан адилгүй согтууруулах ундааг ижил үнээр худалдах, түүгээр үйлчлэх;
- согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах зэргийг хориглох зохицуулалтыг боловсруулсан.

7. Хуулийн төслийн 7 дугаар бүлэгт согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам болон хяналт тавих эрх бүхий субъектүүдийг тодорхойлж, тэдгээрээс хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан.

-oOo-